



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Asian Development Bank

Japan
Fund for
Poverty
Reduction

ОРОН НУТГИЙН НӨӨЦ АШИГЛАН НЭМЭГДЭЛ ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ

Халгайгаар тэжээл бэлтгэх

Халгай нь хавар эрт 5 сарын дунд үеэс ургаж намар 8 сарын эцсээр хагдардаг. Халгайг 35-40 см өндөр болох үед нь хадаад сүүдэрт хатаах, хэрчиж жижиглэх, мушгиа хийх зэргээр боловсруулахад К,В,Д,Е,С витаминуудаар баялаг нэмэлт тэжээл болдог.

Таана, хөмүүл

Говь цөлийн бүсийн бэлчээрт нилээд тархсан витаминаар баялаг ургамал бол таана, хөмүүл юм. Таана хөмүүлийг цэцэглэх үед нь түүж хэрчээд давс, хужиртай хольж багсран зоодойлон хатааж витаминт тэжээл бэлтгэнэ. Зоодойг 1.5-2.0 см зузаан, 5-7 см урт хэмжээтэй хийх тохиромжтой.

Малын сэвс

Хивэгч малын сэвс нь бүх төрлийн малд маш сайн тэжээл болдог. Сайн хатааж бэлтгэсэн сэвс сайн чанарын өвснөөс илүү шимт чанартай, уурагтай. Сэвсний шингэн хэсгийг шингээж авахын тулд няцалсан будаа, үнс, давс, хужир хийх хэрэгтэй.

Адууны халтар хомоол

Адууны халтар хомоолыг 8,9,10 дугаар сард бэлтгэн модны үртсийг няцалсан үр тариа, багсармал, холимог тэжээл, халтар хомоолтой бага зэрэг хольж малд өгч хивлэг авахуулж болно.

Малын яс

Хүнсэнд хэрэглэсэн малын ясаа шатааж, үнсийг нь малын тэжээлд хэрэглэнэ. Хонь, ямаанаас дунджаар 3 кг, адуу, үхрээс 15 кг, тэмээнээс 25 кг яс гардаг гэж үзэхэд эрдэс тэжээл бэлтгэх асар их нөөц бий.

Модны навчис

Хус, улиас, хайлаас, бургас, буйлс зэрэг модны навчийг түүж ногооноор нь хатааж, өөр тэжээлтэй хольж, чийглэж дэвтээж мал тэжээнэ. Нарс, хар модны шилмүүс С,Е амин дэм, протеоноор баялаг. Мөн нэг кг шилмүүсэнд 9 л халуун ус хийж 4-5 цагийн дараа шүүж, төлд аажим дасган өгнө.

Уураг-витаминт өвсний хэрчдэс

Ногоон ургамлын хэрчдэс байдлаар тэжээл бэлтгэн мал тэжээхэд тухайн тэжээлийн шингэц сайжирдаггүй боловч олон талын ач холбогдолтой.

- Богино хугацаанд эврээх боломжтой учраас шимт бодисын алдагдал харьцангуй бага гардаг.
- Өвсний хэрчдсээр мал тэжээхэд идэмж дээшилдэг. Тухайлбал царгасныг хадангуут хонь тэжээхэд идэмж 64-69 хувь, хэрчиж жижиглэн тэжээхэд эрс дээшилж үлдэгдэлгүй иддэг.
- Идэмж, шингэц, шимт чанар тааруухан бүдүүн тэжээлийн (сүрэл, зэгс) идэмжийг дээшлүүлэх боломж бий. Тухайлбал саалийн үнээний тэжээлийн жорд хэрчиж жижиглээгүй 2.5 кг сүрэл оролцуулан тэжээхэд түүний идэмж 32-49 хувиас дээш хэтрэхгүй. Харин хэрчиж жижиглэсэн царгас, сүрэлний (50:50) 4.0 кг хольцоор тэжээх үед сүрэлний идэмж 94-99 хувь байв. Эндээс тооцож үзвэл хэрчиж жижиглэгдээгүй сүрлээр тэжээх үед 1.0, харин хэрчиж жижиглэн царгастай хольж тэжээхэд 1.9 кг сүрэл идэж, сүрэлний идэмж бараг 2.0 дахин дээшилж байна.

Уураг-витаминт өвсний мушгиа

Тэжээллэг чанар сайтай бэлчээрийн ургамал, тухайлбал халгай, бууцны мөлхөө хиаг, ерхөг, таана, хөмүүл, мангир, цагаан лууль болон таримал нэг, олон наст хадлангийн ногоогоор бэлтгэвэл илүү чанартай болно. Өвсний мушгиаг шимт чанар сайтай байх үед эртхэн (25/ҮІ-30/ҮІІ) тухайлбал үет ургамлыг гол иш хатгалт, буурцагт ургамлыг бундуулалтын үеэс хожимдуулалгүй хурааж бэлтгэх хэрэгтэй. Хадсан ногоон массыг бат бэх модон суурин дээр тавьж мунаар хөнгөхөн балбаж ишийг саламлан дэлгэж тавиад 2-3 цаг түр эврээгээд өвсний мушгиа бэлтгэвэл амархан хатна. Өвсний мушгиаг мушгих, дээс адил томох аргаар бэлтгэнэ. Уртхан иштэй биежүүлэгч ургамлын үзүүрийг зөрүүлэн сувиж дээр нь навчирхаг, богино иштэй ургамлаа тавьж хулдах байдлаар мушгиж хоёр үзүүрийг холбож бэхэлнэ. Харин томож хийхэд биежүүлэгч ургамал шаардлагагүй. Өвсний мушгианы урт алд дэлэм, бүдүүн нь 3-4 хуруу (диаметр=5-7 см) байхад тохиромжтой. Тэгэхдээ чийглэг өвсөөр бэлтгэх бол арай нарийвтар, харин чийг бага бол арай бүдүүн байх боломжтой. Өвсний мушгиаг өвөлжөө-хаваржааны дотор, эсвэл салхи нэвт үлээж байхаар тохируулан бэлтгэсэн саравчинд дүүжлэн хатаана.

Боловсруулсан: МААЭШХ-ын эрдэм

шинжилгээний ажилтан Д.Сангажав